МАГИСТРАНТ ОЮУТНУУДЫН ГҮЙЦЭТГЭЛ БА ЗАН ТӨЛӨВИЙН ХАМААРАЛ: ХААИС-ЭЗБС-ИЙН ЖИШЭЭН ДЭЭР

Т.Чимэдцэрэн[1a] , Д.Мягмарсүрэн[2b] , М.Эрдэнэтуяа[3c]

[1]*Хөдөө аж ахуйн их сургууль, Эдийн засаг, бизнесийн сургууль, Менежментийн тэнхим, докторант*

[2]*Хөдөө аж ахуйн их сургууль, Эдийн засаг, бизнесийн сургууль, Менежментийн тэнхим, доктор, дэд профессор*

[3]*Хөдөө аж ахуйн их сургууль, Эдийн засаг, бизнесийн сургууль, Менежментийн тэнхим, докторан*

[a]*chimedtseren.t@muls.edu.mn*

[b]*myagmarsuren.d@muls.edu.mn*

[c]*erdenetuya.m@muls.edu.mn*

Өгүүлэл хүлээн авсан огноо: 20/05/2026
Өгүүлэл хэвлэсэн огноо: 01/07/2026
https://doi.org/10.67207/mrj.2026.15.10

ХУРААНГУЙ

Их сургуулийн оюутнуудын сурлагын амжилт болон зан төлөвийн шинж чанаруудын хоорондын хамаарлыг соёл болон нөхцөл байдлын хүчин зүйлстэй уялдуулан судалсан мета-анализ (нэгдсэн дүн шинжилгээ) одоогоор хязгаарлагдмал хэвээр байна(Chen et al., 2025). 2025 онд хийгдсэн Чэн нарын судалгаагаар мета-анализ нь 1995-2024 оны хооронд хэвлэгдсэн 84 судалгааг хамруулсан судалгаа хийсэн байна. Тэдний олж мэдсэнээр Нийцтэй зан (Agreeableness), Хичээнгүй зан (Conscientiousness), Нээлттэй байдал (Openness) зан чанар нь оюутнуудын сурлагын амжилтанд шууд нөлөөтэй бол Экстраверт (Extraversion) зан төлөвийн хувьд сурлагын амжилтан сөрөг нөлөөтэй байдгийг онцолжээ(Chen et al., 2025). Тиймээс энэхүү судалгаа нь ХААИС-ийн ЭЗБС-д суралцаж буй магистрант оюутнуудын сурлагын амжилтанд тухайн суралцагчийн зан төлөвийн шинж чанар хэрхэн нөлөөлдгийг тодорхойлох зорилгоор хийгдсэн. Хүний зан байдал, шинж төрхийг тодорхойлоход ашигладаг зан төлвийн таван хэмжүүрийг (Big Five personality traits) авч үзсэн. Сурлагын амжилтыг семестрийн голч дүн буюу GPA-аар хэмжсэн болно. Судалгааг хийхдээ ХААИС-ийн ЭЗБС-д суралцаж буй магистрант оюутнуудыг судалсан. Ийнхүү судласан зорилго нь магистрант оюутнуудын зан байдал нь сурлагын чанарт хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорьсон. Судалгааны үр дүнд суурилж багш нарын заах арга зүйг сайжруулах, зөвөлгөө өгөхөд оршиж байна. Мөн гадаад магистрантуудын хувьд гэрээсээ хол суралцах нөхцөл байдалд дасан зохицох, хэлний бэрхшээл болон хувь хүний зан төлөвийн хоорондын хамаарал байгаа эсэхийг авч үзэхийг зорилоо. Хичээнгүй зан (Conscientiousness) чанартай оюутнууд сурлагын амжилттай сайн суралцдаг(Rani Bhattacharjee & Ramkumar, 2025; Rodrigues et al., 2024) (Rajapakshe, 2017)бол харин Невротизм нь ихэнх тохиолдолд сурлагын амжилт нь тааруу байдгыг(Chen et al., 2025) дийлэнх судалгааны үр дүнгүүд харуулж байна. Энэхүү судалгаа нь "Их таван" зан төлөвийн хэмжүүрүүд магистрант оюутнуудын сурлагын амжилт, тэр дундаа голч дүн (GPA)-д хэрхэн нөлөөлж байгааг судалсан болно.

Түлхүүр үг: big 5 personality, зан төлөв, ocean personality, GPA, голч дүн

ОРШИЛ

Ковид19-н хөл хорионы үеэр Герман улсад суралцаж буй оюутнуудын сурлагын амжилтанд зан чанар нөлөөлж байгаа эсэхийг судалж гэрээсээ хол суралцах нь сурлагын чанарт нөлөөлдөг болохыг судалсан олж мэдсэн байна. Судалгааны үр дүнд оюутнуудын хичээнгүй зан чанартай (conscientiousness) Экстраверт (нээлттэй, нийтлэг) зан төлөвийн хувьд өндөр амжилттай суралцдаг бол бусад төрлийн зан чанартай оюутнууд суралцах үйлдэлд сөргөөр нөлөөлдөг гэжээ(Rodrigues et al., 2024). Манай улсад суралцахаар ирж буй Өвөрмонгол болон Хятад оюутнуудын хувьд гэрээсээ хол суралцаж байгаа нь тэдний сурлагын чанарт нөлөөлж байгаа гэж таамаглаж байна. Багш сурган хүмүүжүүлэгчийн хувьд оюутнуудын ямар зан чанар нь сурлагын амжилтанд эерэг, сөрөг нөлөө үзүүлж буйг тодорхойлсноор оюутнуудаа илүү ойлгох, суралцах үйл явцад нь тохирсон арга зүйгээр сургалтыг явуулах шаардлагатай. Түүнчлэн, энэхүү мэдээлэл нь багш нарт оюутнуудынхаа зан төлөвийн онцлогийг таньж мэдэх, улмаар оюутны сурлагыг сайжруулахын тулд өөрийн заах арга барилыг тухайн оюутны зан төлөвт нийцүүлэн өөрчлөхөд хэрэгцээтэй мэдээлэл болох юм(Seman & Ismail, 2019). Зан төлөв нь сурлагын амжилтанд хэрхэн нөлөөлж буйг судалсан судалгаануудаас харахад хичээнгүй зан чанар нь сурлагын амжилтыг урьдчилан таамаглах хүчтэй хүчин зүйл болохыг харуулж байгаа бөгөөд энэ нь өөрийгөө хянах чадвар болон өмнөө тавьсан зорилго ухамсарлан хариуцлагатай суралдаг ажээ. Энэхүү судалгаа нь зан төлөвийн шинж чанар боловсролын үр дүнд ямар ач холбогдолтой болохыг онцолсон бөгөөд энэ нь сурлагын зөвлөгөө өгөх, оюутны хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулахад хэрэгцээтэй мэдээлэл юм.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь ХААИС-ийн ЭЗБС-д суралцаж буй магистрант оюутнуудын сурлагын чанар нь хувийн зан төлөвтэй хамааралтай байгаа эсэхийг тодруулахад оршино.

Судалгааны зорилт

Энэхүү судалгааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах тодорхой зорилтуудыг дэвшүүлэв:

1. Зан төлөвийг тодорхойлох Big5personality болон OCEAN-50 арга зүйг судлах
2. Магистрант оюутнуудын зан төлөвийг тодорхойлох
3. Магистрант оюутнуудын зан төлөв нь сурлагын чанарт нөлөөлж буйг тодорхойлох

Судлагдсан байдал

Их, дээд сургуулийн оюутнуудын хувийн шинж чанар болон сурлагын амжилтын хамаарлыг судалсан бүтээлүүдийг нэгтгэн авч үзэв.

Нэгдүгээрт, хувь хүний суурь шинж чанарууд сурлагын амжилтад хэрхэн нөлөөлдөг талаарх уламжлалт хамаарлыг олон судалгаагаар баталгаажуулжээ. Тухайлбал, хичээнгүй зан болон нээлттэй байдал нь сурлагын амжилтыг урьдчилан таамаглах хамгийн тогтвортой эерэг хүчин зүйлүүд болдог бол, сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдал буюу сэтгэл зүйн тогтворгүй байдал нь сөрөг нөлөө үзүүлдэг болохыг ерөнхий болон бэлтгэл шатны оюутнуудын хүрээнд хийсэн судалгаанууд (Rajapakshe, 2017; Seman & Ismail, 2019; Rani

Bhattacharjee & Ramkumar, 2025), түүнчлэн Chen, Cheung, болон Zeng (2025) нарын өргөн хүрээний мета-анализын үр дүн харуулж байна.

Хоёрдугаарт, энэхүү үндсэн хамаарал нь суралцах орчин болон мэргэжлийн онцлогоос хамааран илүү нарийвчлан судлагдах болсон байна. Тухайлбал, анагаахын сургуулийн оюутнуудын хувьд хувийн шинж чанар нь зөвхөн онолын шалгалтын үр дүнд нөлөөлөөд зогсохгүй, төгсөх шатны эмнэлзүйн практик дахь ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн хариуцлагыг тодорхойлоход чухал үүрэгтэй болохыг Bhagat нар (2019) болон Peters нар (2024) тэмдэглэжээ.

Гуравдугаарт, орчин үеийн судалгааны чиг хандлага нь хувийн шинж чанарыг дангаар нь бус, суралцах үйл явцтай холбоотой бусад хүчин зүйлстэй уялдуулан авч үзэх болсон байна. Дотоод хүчин зүйлсийн хувьд, хувийн зан төлөв нь оюутны шүүмжлэлт сэтгэлгээ болон дотоод мотивацитай харилцан үйлчилж, ерөнхий суурь хичээлүүдийн амжилтад нөлөөлдөг болохыг Yi нар (2025) тогтоосон байна. Харин гадаад хүчин зүйлс болон суралцах орчны өөрчлөлтийн хүрээнд Ковид-19 цар тахлын үеийн зайны сургалтын нөхцөл дэх суралцах сэтгэл ханамж, сэтгэл зүйн тэсвэр хатуужлыг хувийн шинж чанартай холбон судалсан байна (Rodrigues, Rose, & Hewig, 2024). Үүний зэрэгцээ машин сургалтын аргуудыг ашиглан оюутнуудын цахим орчин дахь зан байдлын мэдээлэлд тулгуурлан хувь хүний шинж чанар болон сурлагын амжилтыг урьдчилан таамаглах шинэ арга зүйг санал болгожээ. (Seota, Klein, & van Zyl, 2021).

Судалгааны таамаглал

Таамаглал 1. Зан төлөвийн эерэг шинж чанарууд сурлагын амжилтад нөлөөлдөг

H1a. Магистрант оюутны Хичээнгүй зан чанар (Conscientiousness) өндөр байх нь сурлагын голч дүн (GPA)-д хүчтэй эерэг нөлөө үзүүлнэ.

H1b. Магистрант оюутны Нийцтэй байдал (Agreeableness) нь багаар ажиллах сургалтын үйл ажиллагаатай уялдан сурлагын голч дүн (GPA)-д эерэгээр нөлөөлнө.

H1c. Магистрант оюутны Нээлттэй байдал (Openness) буюу шинэлэг санаачилга гаргах чадвар нь сурлагын голч дүн (GPA)-д эерэг хандлага үзүүлнэ.

Таамаглал 2. Сэтгэл зүйн тогтворгүй байдал болон нийгмийн идэвхийн сурлагын амжилтад үзүүлэх хамаарал

H2a. Магистрант оюутны Невротизм (Neuroticism) буюу сэтгэл зүйн тогтворгүй байдлын түвшин өндөр байх нь сурлагын голч дүн (GPA)-д сөрөг хамаарал үзүүлнэ.

H2b. Магистрант оюутны Экстраверси (Extraversion) буюу нийгмийн идэвхтэй байдал нь академик гүйцэтгэлд төвлөрсөн сургалтын онцлогоос шалтгаалан сурлагын голч дүн (GPA)-д тодорхой хүчтэй нөлөө үзүүлэхгүй (маржинал буюу сул) байна.

Судалгааны арга зүй


Судалгаанд ХААИС-ийн ЭЗБС-д идэвхтэй суралцаж буй нийт 80 магистрант оюутныг ерөнхий олонлог болгон авч үзсэн бөгөөд үүнээс зорилтот түүврийн аргыг ашиглан судалгаанд идэвхтэй оролцсон 79 оюутныг бүрэн хамруулсан болно. Тус сургуулийн магистрын түвшний суралцагчдын нийт тоо хязгаарлагдмал (80 оюутан) бөгөөд

судалгааны хамрагдалт 98.7% буюу ерөнхий олонлогийг бараг бүрэн төлөөлж чадаж байгаа тул түүврийн хэмжээг тогтоох тусгайлсан статистик томьёолол (Survey sample size calculation)-ыг ашиглах шаардлагагүй гэж үзсэн. Судалгааны оюутны зан чанарыг тодорхойлохын тулд Big5personality тодорхойлох зан төлөвийн OCEAN-50 аргыг ашигласан болно. 1930-аад оны үед Гордон Олпорт, Хенри Одберт нар анхлан “Үг хэллэг нь тухайн хүний зан төлөвийг тодорхойлдог” гэх санааг дэвшүүлж, 1940-өөд онд Реймонд Каттел хүний зан төлөвийг 16-н төлөвт хуваасан ба 1960-аад оноос эхлэн Эрнест Тупес, Рэймонд Кристал, Варрен Норман нь шинэчлэн хүний зан төлөвийг таван үндсэн төлөвт хуваажАНУ-ийн тэнгисийн цэргүүдийн зан төлөвийг тодорхойлоход ашиглаж байсан. Улмаар 1990-ээд онд Орегоны судалгааны хүрээлэнгийн профессор Льюис Голдберг “Олон улсын зан төлөвийн асуултын сан буюу IPIP-NEO-120”-ийг үүсгэн байгуулсан бөгөөд тус тестийн богиносгосон хувилбар болох OCEAN-50-н асуулттай тестийг ашигласан болно.

Мэдээллийн үр дүнг R, Rstudio програм ашиглан боловсруулж, зан төлөвийн шинж чанарт үнэлгээ өгсөн.


Судалгааны ажлын үр дүн

Магистрын түвшинд оюутнууд нь бакалавр түвшний оюутнуудтай харьцуулахад суралцах арга барилаа илүү ойлгосон, сурлагын агуулга, мөн чанарыг сайн мэддэг, өөрсдийн карьерээ тодорхойлсон, ажлын туршлагатай, үүрэг хариуцлагаа ухамсарласан байдаг. Тийм ч учраас магистрант оюутнуудын голч дүн нь ихэвчлэн маш ойрхон (3.0 - 4.0 хооронд) байдаг. Ийм "нарийн" хүрээнд зан төлөвийн нөлөөг илүү нарийвчлалтай олж харах нь бакалаврын түвшинтэй харьцуулахад илүү төвөгтэй юм.




Зураг 1. ХААИС-ийн ЭЗБС-ийн магистрант оюутнуудын зан төлөв

Пирсоны корреляцийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд Хичээнгүй байдал болон сурлагын голч дүн хооронд r = 0.186 утга бүхий сул эерэг хамаарал ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь оюутны хариуцлагатай зан төлөв нэмэгдэх тусам сурлагын амжилт дагаад өсөх ерөнхий хандлагатайг илтгэж байна. Гэсэн хэдий ч ач холбогдлын түвшин буюу p-утга нь 0.101 байгаа нь стандарт босго болох 0.05-аас их байгаа тул уг хамаарлыг статистикийн хувьд бүрэн батлагдсан буюу ач холбогдолтой гэж үзэх боломжгүй юм. Мөн 95 хувийн итгэлцлийн интервал нь -0.037-оос 0.391-ийн хооронд буюу "тэг" утгыг дайрч гарч байгаа нь бодит эх олонлог дээр ямар ч хамааралгүй байх магадлалыг үгүйсгэж чадахгүй байгааг харуулж байна.




Зураг 2. ХААИС-ийн ЭЗБС-ийн магистрант оюутнуудын зан төлөв ба GPA хамаарал, нийтэч байдал, хичээнгүй, хариуцлагатай байдал

Магистрант оюутнуудын нийтэч байдал (Extroversion) болон сурлагын голч дүн хоёрын хооронд статистикийн хувьд ач холбогдол бүхий хүчтэй хамаарал байхгүйг харуулж байна. Хэдийгээр улаан шулуун нь нийтэч байдал нэмэгдэх тусам GPA үл ялиг өсөж байгаа мэт харагдавч P утга нь 0.101 буюу стандарт босго үзүүлэлт болох 0.05-аас их байгаа тул энэхүү сул өсөлтийг зүй тогтол биш, харин санамсаргүй тохиолдол гэж үзлээ. Цэнхэр цэгүүдийн тархалт маш сарнимал, тодорхой нэг чиглэлгүй байгаа нь тухайн хүний экстраверт эсвэл интроверт байх нь сурлагын амжилтад нь шийдвэрлэх нөлөө үзүүлдэггүйг баталж байгаа юм. Магистрантуудын хичээнгүй, хариуцлагатай байдал (Conscientiousness) болон сурлагын голч дүн хоёрын хамаарлыг харуулж байгаа бөгөөд улаан шулууны налуугаас үзвэл хариуцлагатай байх тусам сурлагын дүн өсөх эерэг хандлага ажиглагдаж байна. Хичээнгүй, хариуцлагатай оюутнууд илүү сайн сурах магадлалтайг харуулж байгаа юм. График дээрх цэгүүдийн тархалт маш их сарнимал, саарал сүүдэрлэсэн итгэмжлэх муж нь өргөн байгаа нь хариуцлагатай байдал ба сурлагын амжилтын холбоог энэхүү өгөгдлийн хүрээнд шууд зүй тогтол гэж нэрлэж болохоор бөгөөд илүү дэлгэрэнгүй судалгааг хийх шаардлагатай.



Зураг 3. ХААИС-ийн ЭЗБС-ийн магистрант оюутнуудын зан төлөв ба GPA хамаарал, найрсаг, бусадтай зохицох чадвар, сониуч, нээлттэй байдал

Магистрантийн найрсаг, бусадтай зохицох чадвар (Agreeableness) болон сурлагын голч дүн хоёрын хамаарлыг харуулж байна. Үүнээс харахад найрсаг байх тусам сурлагын дүн бага зэрэг өсөх хандлагатайг зааж байгаа ба хичээнгүй оюутнуудаас харьцангуй бага өсөлттэй байна. Цэгүүдийн тархалт маш өргөн, тодорхой нэг шугамд орохгүй байгаа нь магадгүй Хятад, Өвөрмонгол оюутнуудын хувьд Монгол оюутнуудтай хамтран ажиллахад хэлний бэрхшээл байгаа гэж таамаглаж байна. Магистрант нь сониуч, нээлттэй байдал (Openness) болон сурлагын голч дүн хоёрын хамаарлыг харуулж байгаа бөгөөд улаан шулуун нь маш бага налуутай буюу бараг хэвтээ байгаа нь энэ хоёр үзүүлэлтийн хооронд ямар нэгэн мэдэгдэхүйц хамаарал байхгүйг илтгэж байна. Цэгүүдийн тархалт маш их сарнимал байгаа нь тухайн хүний шинэ санаанд нээлттэй, бүтээлч байх чанар нь түүний сурлагын амжилтад шууд нөлөөлдөггүйг харуулж байна. Магадгүй манай улсын сургалтын хуучинсаг, уламжлалт байдал нь шинийг эрэлхийлэгч, сониуч оюутнуудад сөргөөр нөлөөлдөг байж болох юм.



Зураг 4. ХААИС-ийн ЭЗБС-ийн магистрант оюутнуудын зан төлөв ба GPA хамаарал, Сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдал

Сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдал буюу невротизм (Neuroticism) болон сурлагын голч дүн хоёрын хамаарлыг харуулж байгаа бөгөөд улаан шулууны бага зэргийн уруудалт нь онолын хувьд стресс, түгшүүр ихсэх тусам сурлагын дүн үл ялиг буурах хандлагатайг зааж байна. Олон улсын судалгаанууд(Seota et al., 2021)(Yi et al., 2025)(Peters et al., 2024)(Bhagat et al., 2019) дээр невротизм давамгайлсан оюутнуудын сурлагын үзүүлэлт бусад зан төлөв давамгайлсан оюутнуудаас бага байдаг гэсэн дүгнэлттэй мөн нийцэж байна. Манай улсад суралцаж буй магистрант оюутнууд мөн сэтгэл хөдлөлийн хувьд тогтворгүй байвал сурлагын амжилт нь мөн адил буурч байдаг байна.

79 магистрантын хувьд Хичээнгүй байдал, Нийцтэй байдал зан төлөв нь сурлагад эерэгээр нөлөөлөх "хандлага" ажиглагдаж байгаа бол Нервотизм, сурлагын голч дүн хооронд r = -0.186 утга бүхий сул сөрөг хамаарал ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь оюутны сэтгэл зүйн тогтворгүй байдал эсвэл стрессийн түвшин нэмэгдэх тусам сурлагын амжилт нь тодорхой хэмжээгээр буурах ерөнхий хандлагатайг илтгэж байна. Нээлттэй байдал болон Экстраверси хувьд сурлагын амжилтад бага хэмжээгээр эерэгээр нөлөөлөх ерөнхий хандлагатай байна. Шинэ санаа гаргадаг, нээлттэй ханддаг оюутнууд нь сайн суралцаж байгаа ч олон нийтийн арга хэмжээ, нийгмийн идэвхитэй байдал нь сурлагын дүнд төдийлөн хүчтэй нөлөө үзүүлэхгүй байна. Үүнээс дүгнэхэд ЭЗБС-ийн Магистрын түвшний оюутнуудад хичээл зааж буй багш нарын үнэлгээ нь хичээнгүй болон нийцтэй зан төлөвтэй оюутнууд илүү сайн үнэлгээ өгөх хандлагатай бол нийгмийн идэвхи, шинэ санаачлага гаргадаг оюутнууд дараагийн түвшний суралцагч байна. Бидний энэхүү судалгаагаар өмнөх судалгаануудтай адил нервотизм зан чанартай оюутнууд нь сурлагын амжилт хамгийн багатай байна. Регрессийн шугамуудыг тойрсон саарал бүс (итгэлцлийн интервал) нь оноо ихсэх тусам тогтвортой байгаа боловч өгөгдлийн цэгүүдийн тархалт сарнисан байгаа нь энэхүү зан төлөв дангаараа сурлагын амжилтыг тодорхойлох хүчтэй хүчин зүйл болж чадахгүй байгааг илтгэнэ. Гэсэн хэдий ч p-утга 0.10-т ойр байгаа нь цаашид хийх судалгаа, судлаач нар нь түүврийн хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд энэхүү хандлага илүү тодорхой болох боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Хувь хүний зан төлөвийн "Их таван" хэмжүүр сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж буйг харьцуулахад Хичээнгүй зан чанар (Conscientiousness) нь бакалавр, магистр гэсэн түвшнээс үл хамааран сурлагын амжилтыг тодорхойлогч хамгийн тогтвортой, хүчтэй эерэг хүчин зүйл болох нь бүх судалгаагаар нэгэн адил батлагдлаа. Түүнчлэн Невротизм (Neuroticism) буюу сэтгэл зүйн тогтворгүй байдал нь сурлагын голч дүнтэй сөрөг хамааралтай (r = -0.186) байгаа нь олон улсын судалгааны үр дүнгүүдтэй нийцэж байгаа бөгөөд энэ нь магистрантуудын стрессийн түвшин нэмэгдэх тусам сурлагын амжилт буурах ерөнхий хандлагатайг илтгэж байна. Магистрын түвшний сургалтад Нийцтэй байдал (Agreeableness) болон Нээлттэй байдал (Openness) нь сурлагад эерэгээр нөлөөлөх хандлага ажиглагдаж байгаа нь ЭЗБС-ийн сургалтын онцлог болох багаар ажиллах чадвар, шинэлэг санаачилгыг багш нар өндрөөр үнэлж буйн илрэл байж болох ч Экстраверси (Extraversion)

буюу нийгмийн идэвх нь сурлагын дүнд төдийлөн хүчтэй нөлөө үзүүлэхгүй байгаа нь магистрын сургалт илүү академик гүйцэтгэл дээр төвлөрдгийг харууллаа.

Цаашид ЭЗБС-ийн багш нар сургалтын үйл ажиллагаандаа магистрантуудын хичээнгүй болон нийцтэй зан төлөвийг хөхүүлэн дэмжсэн үнэлгээний системийг хэвээр хадгалахын зэрэгцээ невротизм өндөртэй буюу стресс болон сэтгэл түгшилтэд өртөмтгий оюутнуудад зориулсан академик зөвлөгөө, стресс менежментийн дэмжлэг үзүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Мөн сурлагын дүнд бага нөлөө үзүүлж буй нээлттэй байдал болон шинэлэг санаачилгыг сургалтын идэвхтэй аргуудаар (кейс шинжилгээ, инновацын төсөл гэх мэт) дамжуулан үнэлгээний системдээ илүү жинтэй суулгаж өгөх нь оюутнуудыг зөвхөн гүйцэтгэгч бус, бүтээлч сэтгэлгээтэй мэргэжилтэн болж төлөвшихөд туслах юм. Хэдийгээр зан төлөв дангаараа сурлагын амжилтыг тодорхойлох бүрэн хүчин зүйл биш боловч багш нар оюутны зан төлөвийн онцлогт тохируулан заах арга барилаа уян хатан болгох нь сургалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх үндэс болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Bhagat, V., Shetty, C. K., Husain, R., Mat, K. C., Simbak, N. Bin, Aung, M. M. T., & Oo, S. S. (2019). The relationship between big five personality traits and academic performance in medical students. *Research Journal of Pharmacy and Technology*, *12*(9). https://doi.org/10.5958/0974-360X.2019.00721.2

Chen, S., Cheung, A. C. K., & Zeng, Z. (2025). Big Five personality traits and university students’ academic performance: A meta-analysis. *Personality and Individual Differences*, *240*. https://doi.org/10.1016/j.paid.2025.113163

Peters, H., Garbe, A., Breil, S. M., Oberst, S., Selch, S., & Holzhausen, Y. (2024). Big five personality traits of medical students and workplace performance in the final clerkship year using an EPA framework. *BMC Medical Education*, *24*(1). https://doi.org/10.1186/s12909-024-05434-x

Rajapakshe, W. (2017). A Study on the Big Five Personality Dimensions’ Effect on University Students’ Academic Performance. *IOSR Journal of Business and Management (IOSR-JBM)*, *19*(12).

Rani Bhattacharjee, R., & Ramkumar, A. (2025). Effect of big five personality dimensions on the academic performance of college students. *Frontiers in Psychology*, *16*. https://doi.org/10.3389/fpsyg.2025.1490427

Rodrigues, J., Rose, R., & Hewig, J. (2024). The Relation of Big Five Personality Traits on Academic Performance, Well-Being and Home Study Satisfaction in Corona Times. *European Journal of Investigation in Health, Psychology and Education*, *14*(2). https://doi.org/10.3390/ejihpe14020025

Seman, K., & Ismail, Z. (2019). Big Five Personality Traits on Academic Performance Among Foundation Students. *Asian Social Science and Humanities Research Journal (ASHREJ)*, *1*(2). https://doi.org/10.37698/ashrej.v1i2.15

Seota, S. B. W., Klein, R., & van Zyl, T. (2021). Modeling e-behaviour, personality and academic performance with machine learning. *Applied Sciences (Switzerland)*, *11*(22). https://doi.org/10.3390/app112210546

Yi, Z. J., Singh, S. S. B., Li, H. C., Rajun, I. S. A., & Yu, Z. H. (2025). A study of the critical thinking influences, the big five personality traits, and motivation factors on university students’ liberal course achievement. *Humanities and Social Sciences Letters*, *13*(4). https://doi.org/10.18488/73.v13i4.4412